



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөнххайрхан сумын Байгалийн цогцолборт газрын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/23/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас: 99019943

Цахим хаяг: erdenetsetseg.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
<b>3.5.1 Төсвийн төлөвлөлт</b> .....	13
<b>3.5.2 Төсвийн гүйцэтгэл</b> .....	13
<b>3.5.3 Нэмэлт төсөв</b> .....	13
<b>3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн</b> .....	14
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	14
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	14
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	14
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	14
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	15
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	15
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	15
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	15
<b>4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн</b> .....	15
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	16
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	16
<b>5.1 Залруулсан алдаа</b> .....	16
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ӨХЗ	Өмч хамгаалах зөвлөл
ХШУДАГ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
БЦГ	Байгалийн цогцолборт газар

## **1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

---

МӨНХХАЙРХАН СУМЫН  
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН  
ДАРГА М.ОДХҮҮ ТАНАА

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөнххайрхан сумын Байгалийн цогцолборт газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөнххайрхан сумын Байгалийн цогцолборт газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран Adobe Premiere Pro CS6 программыг ашиглан зураг засварлах, самбарын эх бэлтгэх, хяналт шалгалтын SMART программаар хэрэгжүүлэх гар утсыг байгаль хамгаалагч нарт олгосон байна. Смарт программын дагуу хяналт шалгалтын ажлыг гар утсаар хөтөлж бүс нутгийг бүрэн хамарсан хяналт шалгалтын ажлыг явуулах боломж бүрдсэн байна.

### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### **Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэнгүй

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>45,194,329.41</u>	<u>96,232,650.00</u>
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	1,500,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	1,500,000.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	45,194,329.41	94,732,650.00
354	<b>Хангамжийн материал</b>	45,194,329.41	94,732,650.00
35410	Бичиг хэргийн материал	247,200.00	80,000.00
35420	Аж ахуйн материал	20,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	489,189.25	-
35470	Бусад хангамжийн материал	44,437,940.16	94,652,650.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>138,278,198.56</u>	<u>105,198,296.26</u>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	138,278,198.56	105,198,296.26
392	<b>Биет хөрөнгө</b>	135,828,198.56	102,868,296.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	71,065,931.00	71,065,931.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(9,556,267.86)	(13,575,021.54)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	103,252,600.00	101,752,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(64,924,150.10)	(83,436,877.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,642,767.38	49,921,960.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(48,358,490.03)	(34,006,366.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,133,018.43	11,714,418.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,574,884.70)	(4,766,376.94)
39209	Зам, гүүрний байгууламж	6,669,370.00	6,669,370.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(1,521,695.56)	(2,471,340.64)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	2,450,000.00	2,330,000.00
39301	Программ хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(120,000.00)	(240,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,970,000.00	1,970,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<u>183,472,527.97</u>	<u>201,430,946.26</u>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<u>183,472,527.97</u>	<u>201,430,946.26</u>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	183,472,527.97	201,430,946.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	104,260,311.79	104,260,311.79
51101	Өмч: - төрийн	104,260,311.79	104,260,311.79
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	71,418,400.62	89,376,818.91
51210	Өмнөх үеийн үр дүн	71,418,400.62	71,418,400.62
51220	Тайлант үеийн үр дүн	-	17,958,418.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,793,815.56	7,793,815.56
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<u>183,472,527.97</u>	<u>201,430,946.26</u>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	377,216,318.25	482,946,105.90
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	4,544,418.25	68,262,305.90
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,544,418.25	68,262,305.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,105,229.00	3,570,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,105,229.00	3,570,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	372,671,900.00	414,683,800.00
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	336,702,900.00	388,303,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	336,702,900.00	388,303,300.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	35,969,000.00	26,380,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	22,900,000.00	16,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,069,000.00	9,880,500.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	416,330,971.07	463,278,427.46
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	416,330,971.07	463,278,427.46
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	401,085,179.91	377,428,402.46
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	180,971,714.00	221,281,724.00
210101	Үндсэн цалин	127,513,333.00	183,356,159.00
210102	Нэмэгдэл	47,689,381.00	32,024,565.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,769,000.00	5,901,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,484,905.84	28,077,284.00
210201	Тэтгэврийн даатгал	21,575,186.93	19,509,559.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,404,151.57	2,295,238.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,876,278.96	1,779,071.27
210204	Ажилгүйдлийн даатгал	416,481.72	408,491.92
210205	Эрүүл мэндийн даатгал	4,212,806.66	4,084,922.24
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,254,503.00	5,876,617.00
210301	Гэрэл, цахилгаан	476,003.00	739,621.00
210302	Түлш, халаалт	4,671,700.00	5,004,775.00
210303	Цэвэр, бохир ус	106,800.00	132,221.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	33,002,174.00	20,165,732.00
210401	Бичиг хэрэг	589,800.00	513,500.00
210402	Тээвэр, шатахуун	30,141,348.00	17,743,502.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,949,126.00	1,714,630.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	321,900.00	194,100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,205,900.00	10,235,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	39,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	167,900.00	-
210604	Урсгал засвар	2,038,000.00	10,196,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,942,000.00	2,313,000.00
210702	Дотоод албан томилолт	2,942,000.00	2,313,000.00

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	92,888,143.76	52,658,243.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,254,543.76	51,694,708.16
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,720.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	135,735.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,500.00	57,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	57,700.00	123,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	249,780.00	622,600.00
210807	Газрын төлбөр	-	24,600.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	53,335,839.31	36,819,902.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,335,839.31	36,819,902.30
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15,245,791.16	85,850,025.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	38,243,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	38,243,600.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	15,245,791.16	47,606,425.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,245,791.16	47,606,425.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<u>(39,114,652.82)</u>	<u>19,667,678.44</u>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	1,709,260.15
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1,709,260.15
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(1,709,260.15)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<u>(39,114,652.82)</u>	<u>17,958,418.29</u>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<u>375,777,129.00</u>	<u>418,253,800.00</u>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	3,105,229.00	3,570,000.00
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,105,229.00	3,570,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	3,105,229.00	3,570,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,105,229.00	3,570,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	372,671,900.00	414,683,800.00
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	336,702,900.00	388,303,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	336,702,900.00	388,303,300.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	35,969,000.00	26,380,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	22,900,000.00	16,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,069,000.00	9,880,500.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<u>375,777,129.00</u>	<u>418,253,800.00</u>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	375,777,129.00	418,253,800.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	360,531,337.84	332,403,775.00

2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	180,971,715.00	221,281,724.00
210101	Үндсэн цалин	127,075,601.00	183,356,159.00
210102	Нэмэгдэл	48,155,614.00	32,024,565.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,740,500.00	5,901,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,085,180.84	28,077,284.00
210201	Тэтгэврийн даатгал	16,962,585.95	19,509,559.88
210202	Тэтгэмжийн даатгал	1,889,517.15	2,295,238.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,464,573.58	1,779,071.27
210204	Ажилгүйдлийн даатгал	338,230.62	408,491.92
210205	Эрүүл мэндийн даатгал	3,430,273.54	4,084,922.24
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,124,503.00	5,826,617.00
210301	Гэрэл, цахилгаан	776,003.00	756,400.00
210302	Түлш, халаалт	3,241,700.00	4,954,775.00
210303	Цэвэр, бохир ус	106,800.00	115,442.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,665,026.00	19,968,800.00
210401	Бичиг хэрэг	311,700.00	194,900.00
210402	Тээвэр, шатахуун	23,924,000.00	17,745,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,949,626.00	1,758,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	479,700.00	270,900.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,887,200.00	9,824,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	242,300.00	39,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	106,900.00	-
210604	Урсгал засвар	2,538,000.00	9,785,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,942,000.00	2,313,000.00
210702	Дотоод албан томилолт	2,942,000.00	2,313,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	118,855,713.00	45,111,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	118,222,113.00	42,647,915.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	35.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	135,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,500.00	57,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	57,700.00	123,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	2,122,600.00
210807	Газрын төлбөр	-	24,600.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15,245,791.16	85,850,025.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	38,243,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	38,243,600.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	15,245,791.16	47,606,425.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,245,791.16	47,606,425.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	104,260,311.79	7,793,815.56	71,418,400.62	183,472,527.97
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	104,260,311.79	7,793,815.56	71,418,400.62	183,472,527.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	104,260,311.79	7,793,815.56	71,418,400.62	183,472,527.97
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	17,958,418.29	17,958,418.29
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	104,260,311.79	7,793,815.56	89,376,818.91	201,430,946.26

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	391,303,300.00	344,267,081.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	391,303,300.00	344,267,081.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	353,059,700.00	306,023,481.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	262,746,400.00	221,281,724.00
210101	Үндсэн цалин	201,370,400.00	183,356,159.00
210102	Нэмэгдэл	55,201,400.00	32,024,565.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,174,600.00	5,901,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,843,300.00	28,077,284.00
210201	Тэтгэврийн даатгал	22,333,500.00	19,509,559.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,627,400.00	2,295,238.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,102,000.00	1,779,071.27
210204	Ажилгүйдлийн даатгал	525,500.00	408,491.92
210205	Эрүүл мэндийн даатгал	5,254,900.00	4,084,922.24
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,832,000.00	5,826,617.00
210301	Гэрэл, цахилгаан	756,400.00	756,400.00
210302	Түлш, халаалт	4,960,100.00	4,954,775.00
210303	Цэвэр, бохир ус	115,500.00	115,442.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,768,800.00	18,768,800.00
210401	Бичиг хэрэг	194,900.00	194,900.00
210402	Тээвэр, шатахуун	16,545,000.00	16,545,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,758,000.00	1,758,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	270,900.00	270,900.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,039,900.00	5,039,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,900.00	39,900.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,393,000.00	1,393,000.00
210702	Дотоод албан томилолт	1,393,000.00	1,393,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	26,436,300.00	25,636,156.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,862,100.00	25,186,721.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	124,800.00	35.00
210803	Даатгалын үйлчилгээ	135,700.00	135,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,600.00	57,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	46,000.00	46,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210,100.00	210,100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	38,243,600.00	38,243,600.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	38,243,600.00	38,243,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,243,600.00	38,243,600.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	391,303,300.00	344,267,081.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	388,303,300.00	341,267,081.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	388,303,300.00	341,267,081.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	3,000,000.00	3,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	3,000,000.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	26.00	24.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	26,380,294.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	26,380,294.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	26,380,294.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,785,000.00
210604	Урсгал засвар	4,785,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	920,000.00
210702	Дотоод албан томилолт	920,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	19,475,294.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,461,194.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,912,500.00
210807	Газрын төлбөр	24,600.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	26,380,294.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,880,294.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,500,000.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мөнххайрхан сумын Байгалийн цогцолборт газар нь Монгол Алтайн нурууны мөнх цас, мөсөн гол, түүнд зохицон шүтэж амьдрах биологийн төрөл зүйлүүд, ховор амьтан, ургамлыг хамгаалах, амьдрах орчныг хадгалан үлдээх, улмаар даян дэлхийд гарч буй байгаль орчны өөрчлөлтийг хянах, мэдээлэл солилцох, судалгаа шинжилгээ явуулах, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх оновчтой менежментийг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- ✓ *Засгийн газрын шийдвэр болон харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- ✓ *Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ *Төрийн хэмнэлтийн тухай хууль*

БОАЖЯ-ны сайдын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/439 тоот тушаалаар Мөнххайрхан сумын Байгалийн цогцолборт тусгай хамгаалалтын газрыг 26 орон тоотой байхаар баталсан байна. Мөнххайрхан сумын Байгалийн цогцолборт газар нь хамгаалалтын захиргааны 4, байгаль хамгаалагч 15, үйлчилгээний 5 албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тус Байгалийн цогцолборт хамгаалалтын газар нь Мөнххайрхан уулнаас эх аван урсдаг Булган, Үенч, Бодонч голын экосистем, биологийн олон янз байдал, амьтдын амьдрах орчныг тогтвортой хадгалан хамгаалах, Усны тухай хууль болон Байгаль орчны багц хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, байгаль хамгааллын хамтын ажиллагааг сайжруулах, судалгаа шинжилгээ, сургалт сурталчилгаа, хяналт шалгалтын үр өгөөжийг дээшлүүлэх зорилгын хүрээнд төлөвлөгөө гарган гүйцэтгэлийн ханган ажиллажээ.

Хяналт шалгалтын жилийн ажлын графикайг сар, улирлаар гарган батлуулж, хяналтын ажлын нэгдсэн удирдамж боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хяналтын графикт ажлын хүрээнд 5 удирдамжаар 5 төлөвлөгөөт хяналт, 2 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалт, орон нутаг, хууль хяналтын бусад байгууллагуудтай хамран ажиллах төлөвлөгөөний дагуу /Ховд аймгийн Булган, Үенч, Мөнххайрхан сумд/ хамтарсан хяналт шалгалтыг 4 удаа нийт 9 хяналт шалгалт хийжээ. Хяналт шалгалтад 75 иргэн хамрагдаж 10 зөрчил илрүүлсэн байна. Зөвлөн туслах үйлчилгээг 1000 иргэнд үзүүлжээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд тус ажлын хэсэг 2 ажлыг төлөвлөн хэрэгжүүлжээ. БОАЖЯ-ны дотоод аудит, хяналт, шинжилгээ үнэлгээний газраас тус онд хяналт шалгалт хийгдэж 7 зөвлөмж өгсөн байна.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Мөнххайрхан сумын БЦГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 27-ны А/21 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, актлах хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлтийг гаргажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах **шаардлагагүй** гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнххайрхан сумын БЦГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад **нийцсэн** тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөнххайрхан сумын БЦГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22.9 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	1,500.0	1,500.0
Бараа материал	45,194.3	94,732.6	49,538.3
Үндсэн хөрөнгө	138,278.2	110,198.3	(28,079.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>183,472.5</b>	<b>206,430.9</b>	<b>22,958.4</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	183,472.5	206,430.9	22,958.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>183,472.5</b>	<b>206,430.9</b>	<b>22,958.4</b>

Дээрх хүснэгтээс харахад Мөнххайрхан сумын БЦГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22.958.4 мянган төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 410.0 сая төгрөг, өөрийн орлогоос 3.0 сая төгрөг нийт 413.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 21.7 сая төгрөгөөр бууруулж 388.3 сая төгрөг, өөрийн орлогыг 3.0 сая төгрөг нийт 391.3 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотгоогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 388.3 сая төгрөгийг улсын төсвөөс, өөрийн орлогоос 3.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 388.3 сая төгрөг, өөрийн орлогоос 3.0 сая төгрөг нийт 391.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 343.7 сая төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 47.6 сая төгрөгөөр тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71405/80101-Зардал	325,684.2	278,753.4	46,930.8	85.6
2	71405/80802-Тэтгэвэр, тэтгэмж	38,243.6	38,243.6	-	100
3	71405/81701-БХ, нөхөн сэргээх	14,076.2	13,478.0	598.2	95.8
4	71405/81703-Ургамал хамгаалал	13,299.3	13,222.1	77.2	99.4
<b>ДҮН</b>		<b>391,303.3</b>	<b>343,697.1</b>	<b>47,606.2</b>	<b>95.2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дэлхийн байгаль хамгаалах сангаас 16.5 сая төгрөг, давсан орлогоос 9.9 сая төгрөг нийт 26.4 сая төгрөг бүрдүүлж тээвэр шатахууны зардалд 1.2 сая, автомашины урсгал засвар 4.8 сая, томилолт 0.9 сая, сургалтын зардалд 19.5 сая төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр байхгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөнххайрхан сумын БЦГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын гүйцэтгэл, хөрөнгө, бараа материалтай холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг аудитор Д.Эрдэнэцэцэг 2023 оны 01 дүгээр сарын 23-наас 01 дүгээр сарын 27–ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 463.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.3 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Мөнххайрхан сумын БЦГ нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцастай холбоотой тус газраас зардал гараагүй бөгөөд БОЯБХУАДЗ төслөөс 23 ш багц 60.2 сая төгрөгийн үнэ бүхий дүрэмт хувцас ирж үнэ төлбөргүйгээр бараа материалд бүртгэн авсан байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд тус байгууллага нь 2022 онд 12.4 сая төгрөгийн томилолтын зардлыг 17 албан хаагчид олгосон байна. Энэ нь дарга Улаанбаатар хотод удирдах ажилтны зөвлөгөөнд оролцох, 17 байгаль хамгаалагч хамгаалалтын бүсэд хяналтаар ажиллах, сургаалтанд хамрагдах зэрэг ажлаар ажилласан байна.

11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн хувьд тэтгэвэрт гарсан 2 улсын байцаагчид 38.3 сая төгрөгийн тэтгэмжийг төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д заасны дагуу олгосон байна.

12 дугаар зүйлд заасан бусад хангамжийн хувьд холбоотой зардал гараагүй байна.

13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой ямар нэгэн зардал гараагүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 157 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 2 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

БОАЖЯ-ны ХШУДАГ-аас завсрын аудит хийгдсэн тул аймгийн ТАГ-аас 2022 онд завсрын аудит хийгээгүй, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг хянасан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгөгдсөн томилолтоор ажилласан хугацааны томилолтын мөнгө олгохдоо унаа хоолны хөнгөлөлтийг хасаж тооцоогүй 0,2 сая төгрөгийн төлбөрийн акт, жолоочийн замын хуудас гарын үсэг зурж баталгаажуулаагүй, шатахуун олгох зөвшөөрлийн бичиг дугааргүй, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй 3.5 сая төгрөгийн зөвлөмж өгөгдсөн нь бүрэн хэрэгжээгүй байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	216.0	1	216.0	100
Албан шаардлага	-	-	-	-	0
Зөвлөмж	3	3,574.5	2	592.8	16.6
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>3,790.5</b>	<b>3</b>	<b>808.8</b>	<b>58.3</b>

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал нь бүртгэлд тусгагдаагүй хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулах, шатахуун зарцуулалтын дотоод хяналтыг сайжруулах талаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 7.1 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс 7.1 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, алдааг дахин давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө

### 5.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй

### 5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.3 Албан шаардлага

#### 5.3.1 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Замын хуудас засвартай, гарын үсгээр баталгаажуулаагүй, талноор зарлагдсан шатахуун, замын хуудастай зөрсөн, шатахууны тайлан гаргалт хангалтгүй, өмнөх оны зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, хүчин төгөлдөр бус баримтаар шатахуун зарлагдсан, анхан шатны баримт иж бүрэн биш зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэлт: Шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулж анхан шатны баримтын иж бүрдлийг ханган, иж бүрэн, үнэн зөв байх зарчмыг баримтлан ажиллах

### 5.4 Зөвлөмж

#### 5.4.1 Орлого үр дүнтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үнэт цаасны тооцоо хүн бүрээр хийж баталгаажуулаагүй, хяналт шалгалтаар давхардсан тоогоор 48.2 сая төгрөгийн томиллолт, шатахуун зарцуулан байнга явж байгаа ч орлогын гүйцэтгэл хангалтгүй, хяналтын үр дүн дээшлээгүй үнэт цаасны орлогоор 1.8 сая төгрөг бүрдүүлж байгааг харьцуулахад үнэт цаасны орлогыг бүрдүүлэх талаар хангалтгүй ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Өгсөн зөвлөмж: Хяналт сул байгаагаас Байгалийн цогцолборт газраас түүгдэж буй сонгино, эмийн ургамал, түлш гэх мэт байгалийн баялаг зах зээл дээр их хэмжээгээр зарагдаж байгаад дүгнэлт хийж хураамжийн орлого нэмэгдүүлэх

#### **5.4.2 Орлоготой холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын бүсээр нэвтэрч байгаа хүнд даацын нүүрсний тээврийн автомашины хураамжийг иргэнээр тооцож хураамж авсан. Тус Мо Эн Ко ХХК-нь гадаадын хөрөнгө оруулалттай гадаад эзэнтэй аж ахуйн нэгж учир гадаад иргэний хураамжаар тооцож аваагүй. 2021 онд /15049\*3000/45.2 сая төгрөг, 2022 онд 21626\*3000/64.9 сая төгрөг/, буюу зөрүү 99.0 сая төгрөгийн орлого олох боломж алдсан байна. Энэ орлого хамгаалалтын бүсэд ариун цэврийн байгууламж, хогийн цэг байхгүй байгаагаас болж ил задгай бие засаж байгаа байдал болон нүүрс, бусад хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх боломжтой байгааг анхаарч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", БОАЖЯ-ны сайдын 2001 оны 117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, санхүүгийн тайлангийн Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын шалгуурт нийцсэн байх ба санхүүгийн ухаалаг удирдлага болон төрийн албан хаагчийн зан үйл зүй зохистой байх гэсэн шалгуур үзүүлэлттэй нийцээгүй

Өгсөн зөвлөмж: Мо Эн Ко ХХК-тай хүнд даацын машины хураамжийн талаар гэрээ байгуулж баталгаажуулах, бусад аж ахуйн нэгж байгууллагуудын хамгаалалтын бүсээр нэвтэрч байгаа хүнд даацын машины тооцоо судалгаа гаргах, Журамд заасан аялал жуулчлалын хураамж тогтоосон байдалд өөрчлөлт оруулах талаар дээд газартаа санал хүргүүлэн хураамжийн орлогоо нэмэгдүүлэх

#### **5.4.3 Бараа материалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Бараа материалын дансанд бүртгэлтэй зарим хөрөнгийг шууд зарлагдсан, тооллогын комиссын шийдвэрээр акталж устгах хөрөнгийг даргын тушаал шийдвэргүй хөрөнгө устгалтын акт үйлдэлгүй устгасан зөрчлүүд илэрлээ./Хавсралтаар баталгаажуулсан/

Энэ Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэл болон дотод хяналтыг сайжруулж нярвын ажлын хариуцлагыг дээшлүүлэх

#### **5.4.4 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Төсөл хөтөлбөрөөс үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн компьютер, дуран, jps зэрэг хөрөнгийг тооллого хийж капиталжуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийн тооллого хийж картжуулан үлдэгдлийг баталгаажуулах, хөрөнгөд тавих дотоод хяналтыг сайжруулах

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга хийгдээгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэт цаасны тооцоо хүн бүрээр хийж баталгаажуулаагүй, хяналт шалгалтаар давхардсан тоогоор 48.2 сая төгрөгийн томилт, шатахуун зарцуулан байнга явж байгаа ч орлогын гүйцэтгэл хангалтгүй, хяналтын үр дүн дээшлээгүй үнэт цаасны орлогоор 1.8 сая төгрөг бүрдүүлж байгааг харьцуулахад үнэт цаасны орлогыг бүрдүүлэх талаар хангалтгүй ажилласан байна.	1	-					1	-
Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын бүсээр нэвтэрч байгаа хүнд даацын нүүрсний тээврийн автомашины хураамжийг иргэнээр тооцож хураамж авсан. Тус Мо Эн Ко ХХК-нь гадаадын хөрөнгө оруулалттай гадаад эзэнтэй аж ахуйн нэгж учир гадаад иргэний хураамжаар тооцож аваагүй. 2021 онд /15049*3000/45.2 сая төгрөг, 2022 онд 21626*3000/64.9 сая төгрөг/, буюу зөрүү 99.0 сая төгрөгийн орлого олох боломж алдсан байна. Энэ орлого хамгаалалтын бүсэд ариун цэврийн байгууламж, хогийн цэг байхгүй байгаагаас болж ил задгай бие засаж байгаа байдал болон нүүрс, бусад хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх боломжтой байгааг анхаарч ажиллаагүй байна	1	-					1	-
Бараа материалын дансанд бүртгэлтэй зарим хөрөнгийг шууд зарлагдсан, тооллогын комиссын шийдвэрээр акталж устгах хөрөнгийг даргын тушаал шийдвэргүй хөрөнгө устгалтын акт үйлдэлгүй устгасан зөрчлүүд илэрлээ./Хавсралтаар баталгаажуулсан/	1	-					1	-
Төсөл хөтөлбөрөөс үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн компьютер, дуран, jps зэрэг хөрөнгийг тооллого хийж капиталжуулаагүй зөрчил илэрлээ.	1	-					1	-

Замын хуудас засвартай, гарын үсгээр баталгаажуулаагүй, талоноор зарлагдсан шатахуун, замын хуудастай зөрсөн, шатахууны тайлан гаргалт хангалтгүй, өмнөх оны зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, хүчин төгөлдөр бус баримтаар шатахуун зарлагдсан, анхан шатны баримт иж бүрэн биш зөрчил илэрлээ.	1	7,152.0			1	7,152.0		
<b>Дүн</b>	5	7,152.0	-	-	1	7,152.0	4	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Нийт дүн								

**Ховд аймаг дах Төрийн аудитын газар**